**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/66/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим: хуудас<br>www.audit.mn<br>Хөвсгөл аймаг.<br>Мөрөн сум.<br>2022 он | Хөвсгөл аймаг дахь Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ<br>Утас: 99900662 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Л.Мандахнаран<br>Утас: 92118177 Цахим хаяг: Mandakhnaran@audit.gov.mn<br>Ньюбаланс Аудит ХХК-ийн<br>Захирал,чанарын хяналтын менежер Б.Лхагвадорж<br>Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com<br>Аудитор: Д.Гэрэлчулуун<br>Утас: 99509636 Цахим хаяг: d.gerlee98@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын санал дүгнэлтийн хэлбэр 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....13
3. Аудитын тайлан ....13
3.1 Ерөнхий зүйл....13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....14
3.4 Материаллаг байдал ....14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....17
3.8 Аудитын гол асуудал ....17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....18
4. Аудитын илрүүлэлт....18
4.1 Залруулсан алдаа....18
4.2 Төлбөрийн акт. .... 18
4.3 Албан шаардлага... .... 18
4.4 Зөвлөмж.... 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ч.ОТГОН-ЭРДЭНЭ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4,

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/163
танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ч.ОТГОН-ЭРДЭНЭ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 82,051,528.17 | 83,389,006.22 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 82,051,528.17 | 83,389,006.22 |
| 351 | Түүхий эд материал | 212,700.00 | 1,050,600.00 |
| 35130 | Эм боох материал | 212,700.00 | 1,050,600.00 |
| 354 | Хангамжийн материал | 80,528,828.17 | 81,028,406.22 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,261,430.00 | 2,515,778.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 00.00 | 67,581,161.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 935,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,798,451.77 | 9,996,467.22 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 68,468,946.40 | 00.00 |
| 35600 | Мал амьтад | 1,310,000.00 | 1,310,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 673,057,496.17 | 978,975,969.10 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 673,057,496.17 | 978,975,969.10 |
| 392 | Биет хөрөнгө | 658,891,496.17 | 964,672,469.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 639,988,673.00 | 936,320,278.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -44,270,784.31 | -67,216,901.77 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,986,100.00 | 5,994,440.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -14,986,100.00 | 00.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,051,800.00 | 62,689,334.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -25,092,016.68 | -10,708,422.20 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,213,849.00 | 17,372,399.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,079,117.56 | -3,935,194.27 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 59,566,950.90 | 40,262,125.64 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -40,561,608.18 | -19,179,339.88 |
| 39217 | Ном | 3,073,750.00 | 3,073,750.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 14,166,000.00 | 14,303,500.00 |
| 39301 | Програм хангамж | 275,000.00 | 137,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -275,000.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,166,000.00 | 14,166,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 755,109,024.34 | 1,062,364,975.32 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 755,109,024.34 | 1,062,364,975.32 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 755,109,024.34 | 1,062,364,975.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 556,061,108.90 | 556,061,108.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 556,061,108.90 | 556,061,108.90 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 16,295,995.20 | 323,912,741.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 16,295,995.20 | 16,656,790.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 307,255,950.98 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 182,751,920.24 | 182,391,125.24 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 755,109,024.34 | 1,062,364,975.32 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 488,199,748.00 | 768,969,474.58 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 32,813,448.00 | 322,612,674.58 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 32,813,448.00 | 322,612,674.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 32,813,448.00 | 322,612,674.58 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 32,813,448.00 | 322,612,674.58 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 56,338,000.00 | 51,742,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 399,048,300.00 | 394,614,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 261,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 261,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 56,338,000.00 | 51,480,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,338,000.00 | 51,480,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 432,477,565.91 | 461,713,523.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 432,477,565.91 | 461,713,523.60 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 426,586,642.91 | 437,440,570.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 283,738,600.00 | 280,313,966.33 |
| 210101 | Үндсэн цалин | 245,233,200.00 | 188,051,166.33 |
| 210102 | Нэмэгдэл | 19,304,700.00 | 73,062,100.00 |
| 210104 | Урамшуулал | 19,200,700.00 | 19,200,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,265,400.00 | 37,539,846.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,835,800.00 | 26,358,183.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,845,600.00 | 2,584,525.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,297,700.00 | 2,307,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 571,400.00 | 577,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,714,900.00 | 5,712,238.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,047,642.00 | 41,240,655.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,680,000.00 | 2,409,455.00 |
| 210302 | Түлш, халаалт | 37,225,242.00 | 38,708,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 142,400.00 | 122,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,737,645.00 | 12,418,375.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 525,900.00 | 974,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,826,975.00 | 2,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,260,000.00 | 1,000,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 360,000.00 | 261,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,764,770.00 | 1,472,646.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 6,209,929.40 |
| 2105 | Нормативт зардал | 19,467,481.50 | 14,934,164.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,498,900.00 | 2,388,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,968,581.50 | 12,545,664.55 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 755,000.00 | 8,116,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 755,000.00 | 8,116,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 102,000.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 102,000.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 450,500.00 | 1,123,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,500.00 | 583,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 540,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,022,374.41 | 41,682,963.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,631,500.00 | 720,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,502,250.00 | 6,837,552.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,888,624.41 | 34,125,411.65 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,890,923.00 | 24,272,952.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 570,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 570,000.00 | 300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,262,425.00 | 22,784,807.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,262,425.00 | 22,784,807.67 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 58,498.00 | 1,188,145.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 58,498.00 | 1,188,145.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 55,722,182.09 | 307,255,950.98 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 55,722,182.09 | 307,255,950.98 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,061,108.90 | 182,751,920.24 | -45,032,186.89 | 693,780,842.25 |
| С03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 556,061,108.90 | 182,751,920.24 | -45,032,186.89 | 693,780,842.25 |
| С07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 55,722,182.09 | 55,722,182.09 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,061,108.90 | 182,751,920.24 | 16,295,995.20 | 755,109,024.34 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,061,108.90 | 182,751,920.24 | 16,295,995.20 | 755,109,024.34 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 360,795.00 | 360,795.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 556,061,108.90 | 182,751,920.24 | 16,656,790.20 | 755,469,819.34 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -360,795.00 | 00.00 | -360,795.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 307,255,950.98 | 307,255,950.98 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,061,108.90 | 182,391,125.24 | 323,912,741.18 | 1,062,364,975.32 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 455,386,300.00 | 446,356,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 455,386,300.00 | 446,356,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 399,048,300.00 | 394,614,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 261,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 261,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 56,338,000.00 | 51,480,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,338,000.00 | 51,480,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 446,181,300.00 | 426,138,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 446,181,300.00 | 426,138,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 440,290,377.00 | 401,865,847.33 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 283,738,600.00 | 280,313,966.33 |
| 210101 | Үндсэн цалин | 245,233,200.00 | 188,051,166.33 |
| 210102 | Нэмэгдэл | 19,304,700.00 | 73,062,100.00 |
| 210104 | Урамшуулал | 19,200,700.00 | 19,200,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,265,400.00 | 37,539,846.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,835,800.00 | 26,358,183.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,845,600.00 | 2,584,525.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,297,700.00 | 2,307,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 571,400.00 | 577,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,714,900.00 | 5,712,238.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 56,279,502.00 | 41,240,655.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,680,000.00 | 2,409,455.00 |
| 210302 | Түлш, халаалт | 52,457,102.00 | 38,708,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 142,400.00 | 122,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,296,375.00 | 5,825,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 584,800.00 | 287,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,826,975.00 | 2,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,260,000.00 | 1,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 279,000.00 | 240,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 360,000.00 | 261,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,985,600.00 | 1,535,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 35,428,500.00 | 18,659,480.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,711,600.00 | 2,596,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,830,000.00 | 15,103,680.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,886,900.00 | 959,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,863,000.00 | 9,533,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,863,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 482,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 9,051,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 102,000.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 102,000.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 400,000.00 | 1,123,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 583,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 540,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,917,000.00 | 7,559,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 837,000.00 | 720,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,080,000.00 | 6,839,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,890,923.00 | 24,272,952.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 570,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 570,000.00 | 300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,262,425.00 | 22,784,807.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,262,425.00 | 22,784,807.67 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 58,498.00 | 1,188,145.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 58,498.00 | 1,188,145.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 9,205,000.00 | 20,218,000.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 9,205,000.00 | 20,218,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 9,205,000.00 | 20,218,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 9,205,000.00 | 20,218,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,205,000.00 | 20,218,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -9,205,000.00 | -20,218,000.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | ЗӨРҮҮ | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 446,095,000.00 | 422,122,047.33 | 23,972,952.67 | 94.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 446,095,000.00 | 422,122,047.33 | 23,972,952.67 | 94.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 445,795,000.00 | 421,822,047.33 | 23,972,952.67 | 94.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 288,498,100.00 | 280,313,966.33 | 8,184,133.67 | 97.2 |
| 210101 | Үндсэн цалин | 196,235,300.00 | 188,051,166.33 | 8,184,133.67 | 95.8 |
| 210102 | Нэмэгдэл | 73,062,100.00 | 73,062,100.00 | 0.00 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 19,200,700.00 | 19,200,700.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,947,100.00 | 37,539,846.00 | 1,407,254.00 | 96.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,407,300.00 | 26,358,183.00 | 1,049,117.00 | 96.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,884,900.00 | 2,584,525.00 | 300,375.00 | 89.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,307,900.00 | 2,307,900.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 577,000.00 | 577,000.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,770,000.00 | 5,712,238.00 | 57,762.00 | 99.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,428,800.00 | 41,240,655.00 | 1,188,145.00 | 97.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,500,000.00 | 2,409,455.00 | 1,090,545.00 | 68.8 |
| 210302 | Түлш, халаалт | 38,708,800.00 | 38,708,800.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 220,000.00 | 122,400.00 | 97,600.00 | 55.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,563,500.00 | 5,563,500.00 | 0.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 287,900.00 | 287,900.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 240,000.00 | 240,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,535,600.00 | 1,535,600.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 31,283,000.00 | 18,659,480.00 | 12,623,520.00 | 59.6 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,596,000.00 | 2,596,000.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 27,727,200.00 | 15,103,680.00 | 12,623,520.00 | 54.5 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 959,800.00 | 959,800.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 29,751,700.00 | 29,751,700.00 | 0.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,700,000.00 | 14,700,000.00 | 0.00 | 100.0 |
| 210602 | Тавилга | 6,000,000.00 | 6,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,051,700.00 | 9,051,700.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 239,900.00 | 70,000.00 | 169,900.00 | 29.2 |
| 210702 | Дотоод албан томилолт | 239,900.00 | 70,000.00 | 169,900.00 | 29.2 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,523,900.00 | 1,123,900.00 | 400,000.00 | 73.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 583,900.00 | 583,900.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 940,000.00 | 540,000.00 | 400,000.00 | 57.4 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7559000.00 | 7559000.00 | 0.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 720,000.00 | 720,000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,839,000.00 | 6,839,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 300000.00 | 300000.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 446,095,000.00 | 422,122,047.33 | 23,972,952.67 | 94.6 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 394,614,500.00 | 371,829,692.33 | 22,784,807.67 | 94.2 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 394,614,500.00 | 371,829,692.33 | 22,784,807.67 | 94.2 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 51,480,500.00 | 50,292,355.00 | 1,188,145.00 | 97.7 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 51,480,500.00 | 50,292,355.00 | 1,188,145.00 | 97.7 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 28.00 | 28.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 261,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 261,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 261,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 261,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 261,800.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 261800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 261,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 261,800.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн  ахлах аудитор Д.Гэрэлчулуун, аудиторын туслах С.Гэрэлдаваа  нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер  Б.Лхагвадорж , Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор  Л.Мандахнаран, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК –д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн,тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 432.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 307.2 сая төгрөгөөр буюу 3.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая. төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0,0 | 0,0 | |
| Бараа материал | 82.0 | 83.3 | 1.3 |
| Биет хөрөнгө | 658.8 | 964.6 | 305.7 |
| Биет бус хөрөнгө | 14.1 | 14.3 | 0.1 |
| **Нийт хөрөнгө** | **755.1** | **1,062.3** | **307.2** |
| Хуримтлагдсан үр дүн | 16.2 | 323.9 | 307.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **755.1** | **1,062.3** | **307.2** |
| | | | |

Бараа материалын дансны үлдэгдэл 83.3 сая төгрөг болж 1.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Урсгал засварын материал, хоолны материал зэрэг бараа авсан нь үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ. Тайлант онд 6.2 сая төгрөгийн бусад хангамжийн материал дансны хөрөнгө актаар хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,062.3 сая төгрөг болж 307.2 сая төгрөгөөр өссөн нь Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 6 дугаар сарын 23 өдрийн 71 тоот тогтоолоор 2019 онд ашиглалтад орсон цэцэрлэгийн барилгын өргөтгөл болон үнэ төлбөргүй хөрөнгө орлого авсанаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвөөс худалдан авалтаар 20.2 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн Аймгийн ИТХ-ын 2021оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 тоот тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгөнд дахин үнэлгээ хийж орлого авсан 17.5 сая төгрөгийн хөрөнгө, дээд байгууллагаас үнэ төлбөргүй ирсэн 5.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж аймгийн ИТХ-ын тогтоол болон Рашаант сумын ИТХ-ын тогтоолоор 0.02 сая төгрөгийн хөрөнгө актаар хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй нягтлан бодох бүртгэлийн программ нь 2014 онд ашиглалтад орж 5 жилээр элэгдүүлэн анхны өртгөө нөхсөн 0.1 сая төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,062.3 сая төгрөг болж 307.2 сая төгрөгөөр өссөн нь цэцэрлэгийн өргөтгөлийн барилга болон үнэ төлбөргүй ирсэн, дахин үнэлсэн хөрөнгийн дүн зэрэг нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь Улсын төсвийн санхүүжилт 9.3 сая төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй орлого 0.2 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 29.2 сая төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Урсгал засварын зардал, Бараа материал актлалсны зардал, элэгдлийн зардлууд 17.8 сая төгрөгөөр өсөж, Ашиглалтын болон нормативт зардал, цалин, нийгмийн даатгалын зардлууд өөрчлөлтгүй байна. Энэ нь 2021 онд короновирус халдварын өвчлөлийн улмаас цэцэрлэгийн үйл ажиллагаа 3,9,10,11,12 сард цөөн хоног үргэлжилсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсантай холбоотой 0.3 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хуримтлагдсан үр дүнд өөрчлөлт орсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 588.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 588.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 109.4 сая төгрөгөөр бууруулж 479.5 сая төгрөгөөр баталсан байна.

Тухайн төсвийн жилд батлагдсан төсөвт 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу 1 удаа тодотгол хийж, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар 1 удаа төсвийн зохицуулалт хийж тайлант жилийн нөхцөл байдалтай уялдуулан хүүхдийн хоолны зардлаас 37.8 сая төгрөг, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 11.1 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 7.3 сая төгрөг, нийт 56.2 сая төгрөг тус тус хасаж, эд хогшил авах зардалд 20.7 сая төгрөг, шатахууны зардалд 0.5 сая төгрөг, эм бэлдмэл зардалд 0.5 сая төгрөг, аудитын төлбөрт 0.6 сая төгрөг , нэг удаагийн тэтгэмжийн зардалд 0.3 сая төгрөг , төлбөр хураамж бусад зардалд 0.2 сая төгрөг нийт 22.8 сая төгрөгийг нэмж тодотгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэг тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 479.5 сая төгрөгийн төсөв баталснаас 428.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 51.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 394.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 51.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 422.1 сая төгрөгийг зарцуулж 23.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 422.1 сая төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 9.5 сая төгрөгөөр, хоолны зардлыг 12.6 сая төгрөгөөр, тогтмол зардлыг 1.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний болон бусад зардлыг 0.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд 23.9 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

71801 буюу Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 5 зориулалт арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

*Хүснэгт 2.*Төсвийн хөтөлбөр,арга хэмжээ / Сая төгрөг/

| Зориулалт, арга хэмжээний код | Арга хэмжээний нэр | Төсөв | Гүйцэтгэл | зөрүү | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 81834 | Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 241.7 | 236.5 | 22.7 | төвлөрүүлсэн |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 124.8 | 119.8 | | 00 |
| 80109 | ТШЗ ийн байгууллагуудын тогтмол зардал | 51.4 | 50.2 | 1.1 | төвлөрүүлсэн |
| 81807 | Хүүхдийн хоол | 27.7 | 15.1 | 00 | |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 0.3 | 0.3 | | |
| Дүн | | 446.0 | 422.1 | 23.9 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэг тайлант онд Аймгийн боловсролын газраас 0.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Нэмэлтээр ирсэн санхүүжилтийн 0.2 сая төгрөгөөр бараа материалын тайланд ариутгагчтай халуун хэмжигч орлого авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар төсвийн зохицуулалт хийж , Ковид -19 цар тахлын үеийн хариу арга хэмжээний хүрээнд цахим сургалтад зориулж компьютер 14.7 сая төгрөг, ариутгагч 1.9 сая төгрөг, ногоо угаагч 3.5 сая төгрөг нийт 20.2 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 23,9 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: Цалин болон НДШ ийн зардлаас 9,5 сая төгрөг, Хүүхдийн хоолны зардлаас 12,6 сая төгрөг, тогтмол зардлаас 1,2 сая төгрөгийг тус тус хэмнэж 23,9 сая төгрөг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д зааснаар, хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болох www.shilendans.gov.mn -д ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгасан.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолоор төсвийн хөрөнгөөр бараа худалдан авах босго үнийг өөрчилсөн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага аваагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07 ны өдрийн А/608 тоот захирамжаар зарцуулагдаагүй төсвийн 56,2 сая төгрөгийг хасаж 20,7 сая төгрөгийг эд хогшил худалдан авах зардалд нэмж баталсан нь тухайн байгууллагын зарцуулагдаагүй буюу хэмнэсэн төсвийг хөрөнгө, эд хогшил бэлтгэхэд зарцуулдаг байдлыг дээд шатандаа анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад алдаа болон зөрчил илрээгүй

### 4.1 Залруулсан алдаа

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

**4.3 Албан шаардлага**

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

**4.4 Зөвлөмж**

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН:
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС
ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР: Э.БАТ-ЭРДЭНЭ II/25
Огноо:

17200900012.3070665

АУДИТОР Л.МАНДАХНАРАН
Огноо: II/25

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС
ХЯНАСАН:

ЗАХИРАЛ Б.ЛХАГВАДОРЖ
Огноо: 2022.02.19

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР Д.ГЭРЭЛЧУЛУУН
Огноо: 2022.02.17

### 4.3 Албан шаардлага

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Рашаант сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН:
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС
ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР: Э.БАТ-ЭРДЭНЭ
Огноо:

АУДИТОР Л.МАНДАХНАРАН
Огноо:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС
ХЯНАСАН:

ЗАХИРАЛ Б.ЛХАГВАДОРЖ
Огноо:

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР Д.ГЭРЭЛЧУЛУУН
Огноо: